



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/54

Арвайхээр


Албан тушаалын тодорхойлолт батлах  
тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, Төрийн албаны зөвлөлийн “Зөвшөөрөл олгох тухай” 2019 оны 43 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн зөвшөөрлийг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар хавсралтаар, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр хавсралтаар, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар хавсралтаар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100195